

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ
143-Р ТОГТООЛ "ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

2009 он

Баянхонгор

Засгийн Газрын тогтоол			
Хяналтад авсан нийт тоо		30	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		30	
Үүнээс	Биелсэн		21
	Хэрэгжих шатанд		9
	Үүний дотор	90%	7
		70%	1
		50%	х
		30%	1
		10%	х
	Тасарсан		х
Хэрэгжилтийн дундаж хувь: 94,3%			

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ

ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

ЗАСГИЙН ГАЗРЫН 143 ДУГААР ТОГТООЛ "ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2009 он.

Баянхонгор

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Үнэлгээ
Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал			
1.1.	<p>Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; - Албан хаагчийн ёс зүйн дүрэм; - Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь; - Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт; - Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар. 	<p>Төрийн байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны эрхэм зорилго, зорилт, ажилтнуудын эрхлэх ажил, нэр хаяг зэргийг илэрхийлсэн самбар зэргийг хийж иргэдэд танилцуулахаар байршуулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Засаг даргын хэлтэс агентлагуудын мэдээллийг аймгийн вэб сайтад байрлуулж тухай бүр шинэчилж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн самбарт төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг байршуулсан.</p> <p>Тамгын газрын үүдэнд нэгдсэн журмаар байршуулсан самбарт холбогдох мэдээллүүдийг байршуулсан байсныг өөрчилж, хэлтэс тус бүр өөрсдийн үйл ажиллагааны чиглэл, ажилтнуудын эрхлэх асуудал зэргийг агуулсан самбар хийж байршуулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын хууль, тогтоомжуудад нийцүүлэн ЗДТГ-ын дотоод журмыг 2009 онд шинэчлэн үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. /Хэлтэс, тасгууд өөр өөрийн дүрэмтэй./</p>	90
1.2.	<p>Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг олон нийтэд шат дамжлагагүй, ил тод явуулж байх зорилгоор аймгийн Засаг даргаас оны эхэнд удирдах ажилтнуудад үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 6 зүйл бүхий үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа.</p>	100
1.3.	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийг цахим сангаас хувилуулж авахаас бусад тохиолдолд аливаа мэдээллийг үнэ төлбөргүй олгодог. Цахим сангаас мэдээлэл авах журмыг Тамгын газрын даргаар батлуулан мөрдөж ажиллаж байна. Одоогийн байдлаар төлбөртэй үйлчилгээ үзүүлээгүй.</p>	90
1.4.	<p>Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх</p>	<p>Нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийг ХЗДХЯ-нд хүргүүлж улсын бүртгэлд бүртгүүлдэг. Цахим хуудсанд манай аймгийн Засаг даргын 3 захирамж байрлагдсан байгаа. Сүүлийн 2 жилд нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргаагүй байна.</p>	100
1.5.	<p>Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд</p>	<p>Бодлогын баримт бичгийг холбогдох байгууллагаас санал боловсруулж хэлтсийн дарга нар, тухайн салбар хариуцсан мэргэжилтэн урьдчилан танилцаж Засаг дарга саналаа өгч хэвшсэн. 2009 онд аймгийн ИТХурлаас 238 тогтоол, аймгийн Засаг даргаас 529 захирамж гаргаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.</p>	100

	тусгадаг байх		
1.6.	Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	ЗДТГазар иргэдээс өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах хайрцаг ажиллуулсан боловч санал ирэх асуудал бүрхэг байсан тул болиулсан. Долоо хоногийн 4 дэх өдрийн 14-16 цагт ЗДТГазрын дарга иргэдийг хүлээн авч хэвшсэн.	100
1.7.	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх	2009 онд гэр, мөнгөн тусламж зэрэг хөрөнгө санхүүтэй холбоотой өргөдлөөс бусад өргөдлийг цаг хугацаанд нь шийдвэрлэж байна.	90
Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал			
2.1.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх	Байгууллагын стратеги бизнес төлөвлөгөө, Хүний хөөцийн төлөвлөгөө, сургалт мэдлэг чадвар, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.	100
2.2.	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх	Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах, сургаж хөгжүүлэх, албан тушаалд томилж чөлөөлөх зэрэг ажлыг дээрх хөтөлбөр төлөвлөгөөний заалтуудаар зохицуулж байна.	100
2.3.	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх	Байгууллагын үйл ажиллагаандаа SWOT шинжилгээ хийх сургалтыг зохион байгуулж онолын мэдлэг олгосон. Сургалтаар хамт олноо хэд хэдэн баг болгон дасгал ажиллуулж байгууллагынхаа давуу ба сул тал, гадаад, дотоод орчны нөлөө, арга зам боломжийг тодруулан дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг хамт олны хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулан мөрдөж байна.	100
2.4.	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх	Жил бүрийн ажлыг дүгнэж байгууллага, хамт олноороо амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, байгалийн сайханд аялах, улс, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа зарим зохион байгуулалттай арга хэмжээнд хэнийг оролцуулах, Тамгын газрын тэргүүний ажилтан"-г шалгаруулж мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнаж урамшуулдаг нь хамт олон харилцан бие биеэ ойлгож, хүлээн зөвшөөрөх нөхцлийг бүрдүүлдэг. Тамгын газар хамт олондоо тайлангаа тавьж санал асуулга авч өөрийн ажлаа дүгнэн цаашид хийх ажлаа төлөвлөдөг нь байгууллагын удирдлага хамт олонтойгоо ойлголцох, хамт олны ажиллах идэвхийг дээшлүүлэх, удирдлагаас баримталж буй бодлого чиглэлийг албан хаагчид чин сэтгэлээсээ хүлээн авч биелүүлэх, хамт олон доторх уур амьсгал эерэг болох сайн үйлсийн эхлэл болж байна.	100
2.5.	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;	2009 онд аймгийн хэмжээгээгээр төрийн захиргааны сул байгаа 95 ажлын байр зарлагдсаны дагуу төрийн албаны мэргэшлийн шалгалтад 456 иргэн бүртгэгдэн шалгалтад орсоноос 164 иргэн тэнцэж төрийн албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн. Тамгын газар нь 41 орон	100

		тоотой ажиллаж байгаагийн 29 нь төрийн захиргааны албан тушаал байна. 29 албан хаагч бүгд төрийн албаны мэргэшлийн шалгалтад орж тэнцэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдэн нөөцөөс томилогдсон мэргэшсэн албан хаагч байна. Ажлын байрыг нөхөх, ажил албан тушаалд иргэнийг томилохдоо Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох журам зааврын дагуу мэдлэг, мэргэжил, мэргэшил, ур чадварыг харгалзан томилон ажиллуулж байна.	
2.6.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх	Алба хаагчдын аппаратын зөвлөлгөөнийг зохион байгуулж байгууллагын дотоод журмыг хэлэлцүүлэн шинэчилсэн. Алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх ажлыг зохион байгуулж Тамгын газрын бүх алба хаагчид үр дүнгийн гэрээгээ шинэ тодорхойлолтдоо нийцүүлэн шинэчилсэн.	100
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал <i>/ Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүн нээлттэй, ил тод болсон байна./</i>			
3.1.	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх	Төсвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэн 2009 онд дууссан. Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010, 2011, 2012 оны төсвийн төлөвлөлтийг боловсруулан Сангийн ямааер шалгуулан тусгаж цаашдаа нэмэх өөрчлөлтийг тухайн жилийн үндсэн чиглэлд оруулан батлуулж ажиллаж байна.	100
3.2.	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх	2009 оны төсөв, урьд онуудын төсвийн гүйцэтгэл, 2010 оны төсвийн төслийг аймгийн веб сайт bayankhongor.mn сайтад байрлуулан мөн аймгийн ИТХурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн тогтоолын хамт хэлтсийн самбарт байршуулан иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулсан. Тамгын газраас мэдээллийг иргэд байгууллагад чөлөөтэй авах боломж олгосон ч одоогийн байдлаар аваагүй байна.	90
3.3.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх	Төсвийн гүйцэтгэл, хагас бүтэн жилийн тайланг аймгийн bayankhongor.mn сайт, Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийн самбарт тухай бүр байршуулан иргэдэд мэдээлэл хүргэж хэвшсэн	90
3.4.	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр “Зөрчилгүй” дүгнэлт авсан. Аудитын тайланг аймгийн веб сайт, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулсан.	100

3.5.	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх	Аймгийн ЗДТГазарт 2009 оны төсөвт 451340,7 сая төгрөг батлагдсанаас 6 сард тодотголоор 401987,8 сая төгрөг батлагдсан. Оны эцэст давсан орлогоос 49,0 сая төгрөг хуваарьлагдаж 450987,8 сая төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж төсвийн өөрчлөлт гарах тус бүх олон нийтэд мэдээлж ажилласан.	100
3.6.	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх	Одоогоор төлбөртэй үйлчилгээ авсан иргэн байхгүй байна.	90
3.7.	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Цахим сангаас мэдээлэл авах журам боловсруулан мөрдөж байгаа бөгөөд одоогийн байдлаар төлбөртэй үйлчлүүлсэн иргэн байхгүй байна.	90
Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал			
4.1.	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Засаг даргын тамгын газраас 2009 онд худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг “Худалдан авах ажиллагааг тайлагнах журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж төсвийн ерөнхийлэн захирагчаар батлуулан ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулж, орон нутгийн 3 телевиз, 2 сонин болон бусад мэдээллийн хэрэгслээр зарласан . Зарлагдаж байгаа бүх тендерүүдийг Баянхонгор телевиз, Хонгор телевиз, Хөгжлийн ертөнц TV-10- телевизүүдээр тухай бүр зарлуулж , мөн өдөр тутмын Монцамэ мэдээ сонин, 10 хоног тутмын Өнөөгийн Баянхонгор сонинд нийтлүүлж , нээлттэй тендер шалгаруулалт зарлагдсан тендерүүдийг www.e-procurement.mn -т цахим хуудсанд байршуулж мэдээлдэг.	100
4.2.	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас / www.e-procurement.mn /-т байршуулан, тогтмол шинэчилж байх	Монгол улсын Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолд заасан хавсралтын дагуу ВЕБ хуудсанд байршуулах төсөвт өртгийн доод хязгаарын дагуу ажил гүйцэтгэх тендерийг 100 сая , бараа худалдан авах тохиолдолд 50 сая хүртэлх төгрөгийн тендерийн 10 урилга цахим хуудсанд байршуулан үр дүнг нь цаг тутам нийтэлж шинэчилж байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдаж байгаа бүх тендерийг цахим хуудсанд байршуулж хэвшсэн	100
4.3.	Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохоо мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх;	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.5 дахь заалтын дагуу үнэлгээний хорооны гишүүдийн олонх нь худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн байх заалтыг баримтан гишүүдийг сонгож, 47.4 дахь заалтын дагуу 17 тендерийн үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын төлөөлөл, авилгатай тэмцэх үнэлгээний ахлагч , Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөгч, Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчдийг оруулсан.	100
4.4.	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил	Сангийн сайдын 2006 оны 418-р тушаалын 1, 2-р хавсралтын дагуу бараа худалдан авах болон ажил гүйцэтгэх жишиг бичиг баримтын дагуу материалаа боловсруулж тендерт оролцохоор сонирхсон хувь хүн хуулийн этгээдэд	100

	тод мэдээлсэн байх	мэдээллийг ил тод нээлттэй олгох нөхцлийг бүрэн хангаж тендерт оролцогчдын үнийн саналыг ТБОНӨХБАУХАТ хууль болон Сангийн сайдын 2007 оны 81-р тушаал “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу үнэлж тендерийн шалгаруулалт хийгдэж дууссаны дараа мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлж танилцуулж хэвшсэн.	
4.5.	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	2009 онд 10 Тендерийн үр дүнгийн талаарх үнэлгээний хорооны мэдэгдлийг цахим хуудаст нийтэлсэн.	100
4.6.	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх;	Худалдан авах ажиллагааны тайланг Сангийн яамны худалдан авах ажиллагааны газарт 2010 оны 1-р сарын 15-ны дотор хүргүүлж “Сангийн яам” тайланг нэгтгэж цахим хуудсанд байршуулсан. 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яамны www.e-procurement.mn , www.Bayankhongor.mn вэб хуудсанд байршуулсан.	100
4.7.	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	АЗДТГ-т ирсэн гомдлыг хянан үзээд хариуг хүргүүлж гомдол гаргагч тал хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Сангийн яамны худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийн зэрэгцээ тендерийн гомдолтой холбоотой мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагад тухай бүрт нь мэдээлдэг.	100
4.8.	Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх	АЗДТГ-ын газрын хөрөнгө оруулалтын мэргэжилтнийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны чиглэлээр 2007 оноос 2 удаа сургалтанд суусан. 2007 оны 10-н сард Худалдан авах ажиллагааны хөгжлийн төвд худалдан авах ажиллагаагаар мэргэшүүлэх сургалтанд “Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар”-ын мэргэжилтэн, “Өмчийн алба”-ны мэргэжилтнүүд сургалтанд хамрагдаж сертификат авсан. 2009 онд мэргэшүүлэх сургалт зохион байгуулагдаагүй.	30
4.9.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх	2008 онд Худалдан авах ажиллагаанд Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Аймгийн аудитын газраас хяналт шалгалт хийж дүгнэлтийг аймгийн ИТХ болон Засаг даргын зөвлөлд танилцуулсан. 2009 оны үйл ажиллагаанд одоогоор шалгалт хийгдээгүй байна.	70
4.10.	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх	2009 онд худалдан авах ажиллагаатай гомдол ирээгүй байна.	100

---oOo---

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ